



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 01428

Чингис хот

Урьдчилан сэргийлэх арга хэмжээг  
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Засгийн газрын 2020 оны 62, 64, 102, 103 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын №29 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирусын халдвар /КОВИД-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд сунгасугай.

2. Бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн хэвийн горимд шилжүүлж, халдвараас урьдчилан сэргийлж, холбогдох дүрэм, журамд тавигдах шаардлагыг хэрэгжүүлж хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосугай.

3. Соёл урлаг, олон нийтийн арга хэмжээ, худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газруудын үйл ажиллагааг 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн хэвийн горимоор ажиллуулж, Коронавирусын халдвар /КОВИД-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, ариутгал, халдваргүйтгэл заавар, зөвлөмж тавигдах шаардлагыг хэрэгжүүлж хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Коронавирусын халдвар /КОВИД-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Амны хаалтаа зүүцгээе” аяныг эрчимжүүлж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Цагдаагийн газар /хурандаа Б.Батсайхан/, Онцгой байдлын газар /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/, Онцгой комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/ 369 дүгээр захирамжийн 1 дэх заалт, А/78 дугаар захирамжийн 2 дах заалт, А/33 дугаар захирамжийн 2 дахь заалтийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/, Шуурхай штабын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



231010548